

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 02 дугаар сарын 07

№ 01

Улаанбаатар хот

*“Хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж
авахыг компаниас шаардах эрх үүссэн тухай”*

Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсгийг удирдлага болгож, Хишиг-Уул ХК (цаашид “Компани” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөл 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр хуралдаж, дараах тогтоолыг баталж байна:

ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигч Я.Нэргүй нь Компанийн нийт гаргасан хувьцааны 34 хувь буюу хяналтын багцыг нээлттэй дуудлага худалдаагаар дамжуулан 2024 оны 11 сарын 22-ны өдөр худалдан авч, улмаар 2024 оны 12 сарын 31-ний өдөр Нийслэлийн өмч хувьчлах комиссоос “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ”-г олгосонтой холбоотойгоор Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлийн дагуу Компанийн бусад хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрх үүсэж буй тул энэхүү эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг Хавсралт №1-д зааснаар баталсугай.
3. Өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Нийслэлийн өмч хувьчлах комиссоос “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ”-г Я.Нэргүйд олгосон өдөр буюу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоож, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс тархалтыг мэдээг гаргуулан авахыг Гүйцэтгэх захирал Я.Нэргүйд даалгасугай.
4. Компанийн эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнийг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Монголын Хөрөнгийн Бирж ХК-аас ирүүлсэн 03/107 тоот албан бичигт дурдсаны дагуу 4,393.90 төгрөг байхаар тогтоосугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхтэй тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Бирж ХК-д 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн дотор зохих баримт бичгийн хамт хүргүүлсүгэй.
6. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авах сүүлийн хугацааг мэдэгдлийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсэн өдөр буюу 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс хойш ажлын 30 хоногийг дуустал байхаар тогтоосугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхтэй тухай мэдэгдлийг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн дотор өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Батчимэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГОНГОР